

ГХБХБГ-ЫН 03 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2020.03.05.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт Монгол Улсын Засгийн газрын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХХ.1.43-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 14 иргэнд 10776 м2 газрыг тус тус гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар аймгийн Засаг даргын захирамжаар өмчлөлд олгосон бол, аж ахуйн зориулалтаар 3 иргэнд 1231м2 газрыг 18465000 төгрөгөөр давуу эрхээр үнээр нь худалдаж өмчлүүлж, Мөн нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 17 иргэнд 14791 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар Аймгийн Засаг даргын захирамжаар өмчлөлд олгосон.</p> <p>Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газрын хүсэлт, БУАЖ-ын сайд Н.Цэрэнбатын аймгийн Засаг даргад ирүүлсэн 2020 оны 02 сарын 10-ны 01/888 тоот аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын байршлыг газар дээр нь солбицлоор нь тогтоож схем зураг батлав.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлгий хотын төв “Хутты мекен” хороололд баригдах 640 сурагчтай сургуулийн барилгын байршлыг шийдвэрлүүлэх тухай “Көшелик”ХХК-ны 2020.оны 20/18 тоот хүсэлтийг судлан үзэж хангагч байгууллагуудын төлөөлөл болох “СУАТ” компани,”Эрчимбаян-Өлгий” ХК, ЦШСТӨҮГазар, Өлгий сумын Засаг дарга, ХОХБТХэлтэс,ГХБХБГазар, “Көшелик”ХХК-ыг оролцуулан аймгийн Засаг даргын орлогчийн түвшинд эцэслэн шийдвэрлүүлэв.</p> <p>Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн Өлгий, Цэнгэл, Дэлүүн, Улаанхус сумдын Засаг дарга нарт сумын батлагдсан ерөнхий төлөвлөгөөний улаан шугамыг мөрдөж ажиллах талаар аймгийн ГХБХБГазрын даргын 2020 оны 3-р сарын 02-ний 79, 82, 81, 80 тоот зөвлөмжийг тус тус хүргүүлэв.</p> <p>Сумдын газрын даамлуудтай байгууллагаас</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

<p>зохион байгуулсан онлайн хуралд оролцож кадастрын чиглэлээр мэдээлэл хийв.</p> <p>Газар эзэмших эрхийн гэрчилгээг шиншлүүлж газар эзэмшихийг хүссэн 1 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулж ЗДТГ-т хүргүүлэв. Мөн нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд Өлгий сумын газрын даамалтай хамтран 36 иргэний газар өмчлөх, эзэмших газрын кадастрын Лэндменежер програмд оруулав.</p> <p>“Өлгийланд”, “Эл эм ланд” ХХК-ын хийсэн 47 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд оруулсан болно. Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 14 газрын кадастрыг хянаж баталгаажуулав.</p>		
---	--	--

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР